



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 27 өдөр

Дугаар А/237.

Мандалговь

Өвс, тэжээл тооллогын комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "г", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал хамгаалах сангийн өвс, тэжээлийн үлдэгдлийг тоолох комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга: Г.Самданцоодол (Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга)

Гишүүдэд: Б.Мөнхжаргал (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

Б.Бямбасүрэн (Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн)

Б.Баатардорж (Аймгийн Засаг даргын тамгын газрын нярав)

Нарийн бичгийн дарга: Ж.Батбилэг (Хүнс, хөдөө аж ахуйн газрын мал аж ахуйн албаны дарга)

2. Тооллогыг 2021 оны 08 дугаар сарын 30-31-ны өдрүүдэд чанартай зохион байгуулж дүн мэдээг танилцуулахыг комиссын дарга (Г.Самданцоодол)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210977